

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг удирдлагаар хангах, хүч хэрэгслийг хувиарлах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах харилцааг Гамшгаас хамгаалах хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулахдаа Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Нөөцийн тухай хууль, MNS 6980:2022 стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Энэхүү зааврыг үндэслэн гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулна.

Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц

2.1. Төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл
- Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах улсын албаны танилцуулга;
 - гамшгаас хамгаалах улсын албаны танилцуулга;
 - эрсдэлийн үнэлгээ;
 - нутаг дэвсгэр, газар зүй, байгаль, цаг уурын мэдээлэл;
 - нийгэм, эдийн засгийн үзүүлэлт;
 - барилга, байгууламж, дэд бүтцийн мэдээллийг тухайн улсын албаны онцлогт тулгуурлан гаргах.
- Гуравдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ;
- Дөрөвдүгээр бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай арга хэмжээ;
 - Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах төлөвлөгөө
 - Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө
- Тавдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ;
- Хавсралт.

Гурав. Төлөвлөгөө боловсруулах аргачлал

3.1. Төлөвлөгөө боловсруулахдаа улсын алба, мэргэжлийн анги, холбогдох бусад байгууллагатай хамтран ажлын хэсэг байгуулж ажиллах бөгөөд дараах чиглэлийг баримтална. Үүнд:

- Төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах (албан ёсны статистик мэдээ, тоо баримт, дүрэм, журам заавар гэх мэт);
- Төлөвлөгөө боловсруулахдаа гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл, үүсч болзошгүй хохирлын үнэлгээ, нөөц, хүч хэрэгслийг

үндэслэл болгох;

- Тухайн салбарын бүтэц зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг, хүчин чадал, харьяа байгууллага, ажилтан албан хаагчид, салбарын төсөв зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгслийн хүчин чадлыг бодитой тусгах;


- Түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байрны багтаамж, байршил, зам маршрутыг тодорхой тусгах;

- Тухайн салбарын гүйцэтгэх үүрэг чиглэл, тулгарч болзошгүй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

- Гамшгийн үеийн хүнс, шатахуун, бусад бараа материалын бүрдүүлэлт, хангалтын тооцоог боловсруулах;

- Боловсруулсан төлөвлөгөөг сургууль дадлагаар туршиж, дутагдалтай талуудыг засаж дээд шатны байгууллага, албан тушаалтнаар хянуулж батлуулах, тодотгол хийх

3.2. Албаны удирдлага зохион байгуулалт, штаб, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалт тэдгээрийн гүйцэтгэх чиг үүрэг, харилцан ажиллагааны бүдүүвч гаргаж тусгана. Үүнд:



Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ

4.1. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөлд үндэслэнэ.

Жишээ нь: Нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Онцгой байдлын газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”¹-ийн

¹Монгол Улс Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх чадавхийг бэхжүүлэх төсөл (хөгжлийн судалгааны хэлбэрт техникийн хамтын ажиллагаа) Төгсгөлийн тайлан 2-р бүлэг Үндсэн тайлан. УБ хот. 2013 он. х-1-1.

хүрээнд 2011-2013 онд хийсэн, судалгааны ажлын төгсгөлийн тайлангийн 4 дүгээр бүлэг “Газар хөдлөлтийн аюулын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц ба түүний үр дүн”-ээс төлөвлөгөөнд тусгаж болно.

4.2. Болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагаанд өртөж болохуйц эрсдэлтэй цэгүүдийг тодорхойлсон зураглал хийх;

4.3. Салбарын хэмжээнд үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, бүх төрлийн харилцаа холбооны суваг болон зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;

4.4. Төрийн үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагааны бүдүүвч гаргах, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх;

4.5. Гамшгийн үед салбарын хэмжээнд хүч хэрэгслийг үе шаттай хэрхэн татан оролцуулах, гамшгийн нөөцийг хаана, ямар хэмжээтэй бүрдүүлэх;

Тухайлбал: Улсын алба, мэргэжлийн ангийг өргөтгөн ажиллуулах, нөхөн хангалт хийх зорилгоор бүх шатны Засаг даргын Тамгын газар, цэргийн штаб, эрүүл мэндийн газруудтай хамтран цэргийн хоёрдугаар үүрэгтэн буюу цэргийн насны цэргийн алба хаагаагүй иргэд, дүйцүүлэн хаасан иргэд, **оюутнуудыг татан оролцуулах талаар тусгана.**

4.6. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж хүчитгэх, шинэчлэн барих ажлыг тусгах;

4.7. Гамшигт нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, эрчим хүч, дулаанаар тасралтгүй хангах асуудлыг олон улсын хүмүүнлэгийн тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохицуулахаар тусгах;

Тухайлбал: Гамшгаас хамгаалах улсын алба газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгцээт бараа материалын тооцоо, судалгаа (1000, 10000 хүнийг 3, 7, 30 хоногоор)-г гаргаж холбогдох хуулийн этгээд, иргэнтэй гэрээ байгуулах.

4.8. Гамшгийн үед шаардлагатай хүч хэрэгсэл, бараа материал, тоног төхөөрөмжийг шуурхай тээвэрлэх (бараа материалыг тээвэрлэх үндсэн болон нөөц зам маршрутыг тогтоох, зураглал хийж төлөвлөгөөнд тусгах) тогтолцоог бүрдүүлэх, шийдвэрлэсэн байх.

4.9. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөлийн төлөвлөгөөнд жил бүр хэрэгжүүлэх ажлын саналыг дараах чиглэлээр хүргүүлж хамтран ажиллах. Үүнд:

4.9.1. Нэг. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

4.9.2. Хоёр. Гамшгаас хамгаалах сургалт дадлага, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;

4.9.3. Гурав. Газар хөдлөлтөд тэсвэргүй барилга, байгууламж, дэд бүтцийг хүчитгэх, буулгаж шинээр барих замаар газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах, дахин төлөвлөх, зарлан мэдээллийн системийн хүрэлцээг сайжруулах;

4.9.4. Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгийн үед ашиглах хүнсний болон хүнсний

бус бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нөөц бүрдүүлэлтийн чиглэлээр болзошгүй эрсдэлийг тоон үзүүлэлтээр тооцон гаргаж эрсдэлийг бууруулах, чадавхыг бэхжүүлэх зэрэг зорилго, зорилт дэвшүүлж хэрэгжүүлнэ.

4.10. Онцгой байдлын байгууллага нь улсын алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл бэлэн байдал хариуцсан ажилтан, сайн дурын бүлэг, хэсгүүдтэй хамтран алба, мэргэжлийн ангиудын сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах;

4.11. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн сургалт бэлтгэлийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/323 дугаар тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”-ын дагуу зохион байгуулах.

Тав. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай арга хэмжээ

5.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед харилцаа холбоог зохион байгуулж, зарлан мэдээллийг албаны хэмжээнд дамжуулах;

5.2. Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед улсын албаны чиг үүргийн хүрээнд голомтын бүсийг тодорхойлж үүссэн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээг хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

5.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдад мэдээлэл хүргэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, онц байдал зарлах болон холбогдох бусад шийдвэрийг гаргуулах талаар дурьдах;

5.4. Гамшгаас хамгаалах улсын албаны шуурхай штаб байгуулж албаны хохирлын тухай мэдээлэл цуглуулж, үүссэн нөхцөл байдлыг үнэлж эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөх;

5.5. Нэрвэгдсэн хүн амын судалгаа болон хохирол, хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ гаргах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийг тодотгох;

5.6. Гамшгийн голомтод холбоо зохион байгуулах, Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн анги, салбарыг дайчлах, хүч хэрэгслийг татан төвлөрүүлэх, тусгай чиг үүргийн шуурхай бүлэг томилон ажиллуулах;

5.7. Улсын Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллагааг зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох арга хэмжээг шуурхай авах;

5.8. Нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгслээр дамжуулан хүргэх талаар тусгах;

5.9. Улсын онцгой комисс, Шуурхай штабаас гаргасан шийдвэр, гамшгийн хохирлын талаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн 72 цагийн хугацаанд хүний амь нас аврах, гал унтраах, хэв журам сахиулах эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүн, техник, бараа материалын нөөцийг хуваарилах;

5.10. Харьяа байгууллагуудын онц чухал объектыг хамгаалалтад авах, зам талбай, харилцаа холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны инженерийн барилга, байгууламж, дэд бүтцийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, болзошгүй хоёрдогч хөнөөл үүсэхээс хамгаалах арга хэмжээг тодорхой тусгах;

5.11. Монгол Улсын Засгийн газар, Гадаад хэргийн яам нь Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчдийн газраар дамжуулан гадаад улс орон, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн тусламж авах хүсэлт гаргах талаар тусгах;

5.12. Гамшгийн голомтод зам гарцыг чөлөөлж, хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын бүс тогтоож эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах;

5.13. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгслийн харилцан ажиллагааг тухайн Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөр дамжуулан мэдээлэл солилцож, эрэн хайх, аврах, гал унтраах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний болон нэрвэгдэгсдэд үзүүлэх бүх төрлийн хангалтыг зохион байгуулах (хоол хүнс, шатах тослох материал, байр сууц, эм тариа, дулаан хувцас, тоног хэрэгсэл г.м.);

5.14. Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллага, Дотоодын цэргийн хүч хэрэгслийг харилцан ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэх, шаардагдах ажилтнууд, хүч хэрэгслийг орон нутгаас дайчлан гаргах, тэдгээрийн хангалтын асуудлыг зохион байгуулах, хариу ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хүч хэрэгслийн уялдаа холбоо, үйл ажиллагааг зохион байгуулах шуурхай штаб (хээрийн штаб)-ыг байгуулах;

5.15. Түр цугларах талбайд цугласан иргэдийг бүртгэх, зааварчилгаа өгөх, гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах талаар тусгах;

5.16. Гамшгийн үед өөрийн салбарын хариуцсан чиг үүргийн хүрээнд хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэсэн ямар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар **дурдана.**

Тухайлбал: Газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн иргэдийг эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, ангилан ялгах, зам гарц чөлөөлөх, аюулгүй газар тээвэрлэх, түр байр, эмнэлэг дэлгэх, нас барагсдыг зөөвөрлөх, хадгалах, таниулах, оршуулах ажлыг зохион байгуулах.

5.17. Нүүн шилжигчдийг дамжин өнгөрүүлэх болон хүлээж авах, хүмүүнлэгийн тусламж үйлчилгээг хүргэх, зохион байгуулахад тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн алба, мэргэжлийн анги, холбогдох байгууллагуудыг татан оролцуулахаар төлөвлөх;

5.18. Түр байранд иргэдийг хүлээн авах, шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцасны хангалт, эмнэлгийн анхны тусламж, сэтгэл заслын болон бусад төрлийн тусламж үзүүлэх тооцоо судалгааг нарийвчлан гаргах;

5.19. Олон улсын байгууллага, хандивлагч орон, иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив тусламжийг хүлээн авах, зохицуулалт хийх.

Зургаа. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ

6.1. Улсын албаны шуурхай штаб хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөсөн байх;

6.2. Тухайн салбарын хохирлын үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн яаралтай хийгдэх ажлыг эрэмбэлэх, хэрэгжүүлэх, зохион байгуулах;

6.3. Гамшгаас хамгаалах улсын албадын харилцан ажиллагаа. Үүнд:

Д/д	Улсын албаны чиг үүрэг /өөрт хамаарахыг бичнэ/	Хамтран ажиллах улсын алба
1.	Гамшгийн үеийн холбоо, мэдээллийг зохион байгуулах шаардлагатай холбооны хэрэгслийн тооцоог судалгаа, хангалт хийх	ХХМТЯ, БХЯ, ХХЕГ, ОБЕГ
2.	Эрүүл мэндийн үйлчилгээ, эм, тариа, боох материал болон бусад зүйлсийн хангалтыг зохион байгуулах	ЭМЯ, БХЯ, ОБЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
3.	Орон байр, дулаан хувцас, бусад нэн шаардлагатай материал хэрэгслийн хангалт хийх	БХБЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, БХЯ, ЗТЯ, ЭХЯ, ОБЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
4.	Хоол, хүнсний хангалт үйлчилгээг зохион байгуулах	ХХААХҮЯ, БХЯ, ОБЕГ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
5.	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний хангалтыг зохион байгуулах, тусламжийн бараа материал татах, хүргэх ажилд шаардагдах тээврийн хэрэгслийг зохион байгуулах	ЗТЯ, БХЯ, ОБЕГ, ИНЕГ, УБТЗ, МУЗН,
6.	Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлан эрэн хайх аврах хор уршгийг арилгах арга хэмжээнд татан оролцуулах	БХБЯ, ХЗЯ, УУЯ, ЭХЯ, ЗТЯ, ХХААҮЯ, БХЯ, ХНХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ, МУЗН
7.	Түлш эрчим хүчээр хангах ажлыг зохион байгуулах	ЭХЯ, УУЯ, БХЯ,
8.	Ус, дулаанаар хангах ажлыг зохион байгуулах	БХБЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, НЗБ,
9.	Шатах, тослох материал, шатахууны хангалтыг зохион байгуулах	ГХЯ, ЗТЯ, СЯ, ОБЕГ, ИНЕГ, УБТЗ,
10.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах ажлыг дараах байдлаар зохион байгуулахдаа тусламжийн бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	ГХЯ, СЯ, ГЕГ, ХХЕГ, ИНЕГ, МУЗН
11.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг тээвэрлэх ажлыг зохион байгуулах	БХЯ, ЗТЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ, ШШ
12.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хадгалах, хамгаалах асуудлыг зохион байгуулах	ХХААҮЯ, ЗТЯ, ГЕГ, ОБЕГ, ИНЕГ, ЦЕГ, МУЗН, НЗБ, ШШ,
13.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг бараа материалыг хуваарилах асуудлыг зохион байгуулах	СЯ, ЗХЖШ, ОБЕГ, ЦЕГ, МУЗН, ШШ, НЗБ,
14.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг олгох, түгээх асуудлыг зохион байгуулах	ОБЕГ, УБЕГ, ЦЕГ, МУЗН, НЗБ, ШШ, ОУБ (кластер),
15.	Бараа материал болон олголт, тараалт, хүргэлтийн асуудлуудад хяналт тавих асуудлыг зохион байгуулах	ЗТЯ, ОБЕГ, ЦЕГ, ШШ, НЗБ, МУЗН, ОУБ (кластер)

6.4. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардал, хөрөнгийг яаралтай шийдвэрлүүлэх талаар тусгах.

6.5. Засгийн газар, Улсын онцгой комисс, Шуурхай штаб, Улсын алба, мэргэжлийн ангиуд сэргээн босгоход хүн, техник, бараа материалаар тасралтгүй хангах арга хэмжээ авах талаар тусгана.

Тухайлбал: Гамшгийн голомтод барилга, дэд бүтцийн байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах, нуранги, хог хаягдлыг тээвэрлэх, устгах, зам гарцыг чөлөөлөх, орчны бохирдлыг саармагжуулах, хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зэрэг ажилд чиг үүргийн дагуу оролцоно.

Долоо. Хавсралт

7.1. Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргын тогтоол, албан даалгавар, тушаал, хурлын тэмдэглэл, Сайд бөгөөд улсын албаны даргын тогтоол, албан даалгавар, тушаал шийдвэрийн баримт бичгийн төслийг боловсруулж хавсралтаар болон цахим хэлбэрээр хадгалсан байх;

7.2. Улсын албаны онцлогт тулгуурлан газар хөдлөлтийн үед ажиллах үндсэн болон нөөц хүч хэрэгслийн судалгаа, тооцоог нарийвчлан гаргах;

7.3. Нэн чухал дэд бүтэц (цахилгаан, дулаан, цэвэр бохир усны шугам, зам гүүр), барилга, байгууламжийг сэргээн засварлахад шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын нөөцийн судалгааг гаргах;

7.4. Гамшигт өртсөн, түр байранд байрлуулсан иргэд, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хүнс, майхан, дулаан хувцас, шатахуун болон бусад хэрэгцээт бараа материалын тооцоо судалгааг гаргах;

7.5. Эрэн хайх, аврах, ажиллагаа явуулах, гамшигт өртсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэх зам гарцыг тэмдэглэсэн байрзүйн болон план зурагтай байх.

7.8. Улсын албаны хэмжээнд зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч, утас, гэрийн хаягийн бүртгэл, тодотгол хийсэн байх.

Найм. Төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал

8.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, сэргээн босгох үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад мэргэжлийн байгууллагын үүрэг, оролцоог хангасан байх;

8.2. Гадаад орны туршлагыг судалж, шаардагдах мэдээ, мэдээллийг боловсруулж, холбогдох байгууллагын мэргэжлийн хүмүүсийн оролцоотой төлөвлөгөөг боловсруулна.

---oOo---